

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
 ГАЗРЫН 2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
 /2019.03.26 - 2019.04.25/**

2019 оны 04 дүгээр сарын 25

Замын-Үүд сум

№	Бүтээгдэхүүний нэр	Биелэлт
1	2	3
<b>Нэг. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр</b>		
1	Гадаадын иргэнд Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл, хувийн хэргээр зорчих урилга, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгох, сунгах, хасах, визийн ангилал өөрчлөх, түр ирэгчийн бүртгэл, хасалт хийнэ.	Түр ирэгчийн хасалт хийлгэхийг хүссэн БНХАУ-ын 47 иргэн, Зөрчлийн тухай хууль зөрчсөн БНХАУ-ын 22 иргэнд хасалт хийсэн байна.
2	Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулна.	Монгол Улсад хууль бусаар хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 2 иргэнийг ГИЭЗБТх-ийн 37.1.7, Зөрчлийн тухай хуулийн 16.2-1.4-д зааснаар торгуулийн арга хэмжээ авч албадан гаргасан.
3	Монгол Улсад байх, буцах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй, ирсэн зорилгоосоо өөр төрөл ангиллын визтэй зорчиж буй гадаадын иргэнийг хилээр нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авч, буцааж буй үндэслэлийг нарийн тогтоож материал бүрдүүлэн ажиллах	Тус газрын хяналтын улсын байцаагчид Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1.6-д заасны дагуу Монгол Улсад байх болон буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй БНХАУ-ын 201 иргэнийг улсын хилээр нэвтрүүлэлгүй буцаан ажилласан.
4	Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэдийн зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллана.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн 2 орны 18 иргэнд 1,290,000.00 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

1	2	3
5	Хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулах	Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ДГ-2019/04 дугаар удирдамжын дагуу Хяналтын Улсын ахлах байцаагч Б.Баярхүү, хяналтын улсын байцаагч Б.Сүлд-Очир, мэргжилтэн П.Гантулга нарын бүрэлдэхүүнтэйгээр 04 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсэрт гадаадаас ажиллах хүч авч үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт, шалгалтыг явуулж шалгалтаар нийт 10 аж ахуйн нэгж байгууллагын 27 иргэний бичиг баримт, виз, оршин суух зөвшөөрөлд шалгалт хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчлийг илтгэх хуудсаар газрын даргад танилцуулан ажилласан.
<b>Хоёр. Захиргаа, удирдлага, хүний нөөцийн чиглэлээр</b>		
6	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх, санал хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас хайрцаг/ дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Тайлант хугацаанд албан хаагчдаас чөлөө хүссэн 6 өргөдөл ирснийг шийдвэрлэн ажилласан.
7	Цагдаагийн байгууллагатай хамтран “Хар тамхи сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршиг, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалт зохион байгуулах	Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “Хар тамхи сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршиг, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалт зохион байгуулж сургалтанд нийт 14 албан хаагч хамрагдсан.

1	2	3
<b>Гурав.Санхүүгийн чиглэлээр</b>		
8	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	<p>“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган ажилласан талаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тухай бүрт нь оруулах мэдээлэл-8</li> <li>✓ Сар бүр оруулах мэдээлэл-3 нийт 11 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны сайтад шивж байршуулсан. Мөн 03 дугаар сарын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн сарын тайланг 2019 оны 04 дүгээр сарын 02-ний өдөр Хяналт шинжилгээ, дотоод аудит орон нутгийн хэлтэст хүргүүлэн ажилласан.</li> </ul>
9	Тэмдэгтийн хураамжийн орлого, хүү торгуулийн орлого, визийн хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.	2019 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Төв газраас тэмдэгтийн хураамжийн орлого 89,812,400.00 төгрөг, Дорноговь аймаг дахь газраас тэмдэгтийн хураамжийн орлого 100,000.00 төгрөг, хүү торгуулийн орлого 1,536,000.00 төгрөг Замын-Үүд сумын Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.
10	Төвлөрүүлэн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан нэгтгэн, статистик болон бусад мэдээ тайланг гаргаж төвд хүргүүлэх	2019 оны 03 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр гарган Замын-Үүд сумын Төрийн сангийн мэргэжилтнээр хянуулан, Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган ndaatgal.mn цахим сайтад шивж, 23 албан хаагчийн нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийн, нийгмийн даатгалын тасгаар баталгаажуулсан.